



Ерөнхий сайд У.Хүрэлсүх Туул голын сав газрыг хамгаалахыг үүрэгдлээ



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх өнгөрсөн долоо хоногт Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаатай танилцах үеэрээ туул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч сүйдсэн газар нутгуудад нөхөн сэргээлтийн ажлыг цаг алдалгүй хийх, Хөвсгөл нуураа хамгаалах, Туул голын сав газрыг хамгаалах зэрэг чиглэлд онцгой анхаарч ажиллахыг үүрэг болголоо. *Эх сурвалж: БОАЖЯ /https://www.mne.mn/?p=12686#, https://www.24tsag.mn/a/186207*

“КОВИД-19 цар тахлын үед ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежментийг хангах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалт болов



“Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 6-р зорилго болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран “КОВИД-19 цар тахлын үед ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежментийг хангах нь” Зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 10-р сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтад Монголын МСС-г төлөөлж Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал Л.Өнөржаргал, Хаягдал ус дахин боловсруулах төслийн мэргэжилтэн Б.Батдэлгэр нар оролцов. *Эх сурвалж: Монцамэ агентлааг /https://www.montsame.mn/mn/read/239729/*

“Ус хангамж, ариутгах татуургын зардал нөхөх асуудал, Хөрөнгийн менежмент” сэдэвт сургалт эхэллээ



Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС) болон Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл (Усны зохицуулах зөвлөл) хамтран Орон сууц, нийтийн аж ахуй, тэр дундаа Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд “Ус хангамж, ариутгах татуургын зардал нөхөх асуудал, Хөрөнгийн менежмент” сэдэвт зургаан өдрийн сургалтыг зохион байгуулж байна. 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Төр, засгийн үйлчилгээний Элит төвийн Хурлын танхимд эхэлсэн тус сургалт 10 дугаар сарын 31 болон 11 дүгээр сарын 4-7-ны өдрүүдэд үргэлжлэх бөгөөд салбарын нийт 340 гаруй төлөөллийг хамруулж байгаа юм. *Эх сурвалж: Монголын МСС /https://mca-mongolia.gov.mn/news/aquapedia/imagine-a-day-without-water/*

Дунд голын Улаанбаатар цэгийн орчимд нитритийн азот хүлцэх агууламжаас хоёр дахин давжээ



Цаг уур, орчны шинжилгээний газраас ажлын төлөвлөөний дагуу Нийслэлийн нутаг дэвсгэр орчмын голын усанд хийсэн хяналт, шинжилгээгээр, Туул голын дагууд усны ууссан хүчилтөрөгчийн горим хэвийн, Улаанбаатар хотоос дээш болон хот орчимд усны чанар сайн, голын ус маш цэвэр байсан ба ТЦБ-аас гарч буй хаягдал бохир ус нийлснээс доош буюу Сонгинооос Алтанбулаг хүртэлх хэсэгт ч мөн адил голын усанд их бохирдол, онцгой их бохирдлын түвшинд хүрсэн бохирдолтой үзүүлэлт өмнөх сарын адил ажиглагдаагүй байна. Харин Дунд голын Улаанбаатар цэгийн орчимд голын усанд нитритийн азотын бохирдол хүлцэх агууламжаас хоёр дахин давжээ. *Эх сурвалж: Gogo.mn /https://gogo.mn/r/mq02e/*

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ



- * ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгээс санаачлан “Ус, усан орчны бохирдол, урсацын өөрчлөлт” сэдэвт нээлттэй семинарыг 11 дүгээр сарын 12-ны өдрийн 11:00-12:30 цагт ШУА-ийн Хүрээлэнгүүдийн Нэгдсэн 2-р байрны 4 давхарын хурлын танхимд зохион байгуулна. (Хөтөлбөрийг цахим шууданд хавсаргав) *Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн*
- * ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль, Геологи, гидрогеологийн салбар, мэргэжлийн холбоодоос зохион байгуулж буй “Монгол орны гидрогеологи, инженер геологи, геоэкологийн асуудлууд” сэдэвт ЭШ-ий цахим хурал 2020 оны 11 үгээр сарын 6-нд болно. (Дэлгэрэнгүй танилцуулгыг цахим шууданд зургаар хавсаргав) *Эх сурвалж: ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль, Геологи, гидрогеологийн салбар*

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ



- ⇒ 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ХУД-ын 41-р цэцэрлэгийн ахлах, дунд бүлгийн 200 хүүхэд “Цэнгээ усны нөөц, байгаль хамгаалах төв”-өөр зочилж, амьтан, ургамлаа хайрлах, усаа гамнаж, тог цахилгаан хэмнэх талаар ойлголт авчээ. *Эх сурвалж: https://ikon.mn/n/20m2*
- ⇒ Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутгаар урсах Хэрлэн гол орчмын цэвэрлэгээг 2020 оны 10 сарын 28-ны өдөр 14 цагаас зохион байгуулж, нийт 160 орчим хүн оролцон, 163,2 га талбайгаасаа 17,6м3 хоо хаягдлыг цэвэрлэн Өндөрхан хот тохижилт ОНТҮГ-ын хоо ачилтын таван машинаар аймгийн төвлөрсөн хогийн цэгт хаяжээ.